

М.Ж.Адлер
Философи нь шинжлэх ухаан, шашин хоёроос
хэрхэн ялгагддаг вэ?

Биднийг философийн агуу их үзэл санааны талаар ярилцахаар шийдэх үед хайр дурлал, ажил хөдөлмөр, урлаг гэх мэт нэлээд тодорхой үзлүүдийн адил ерөнхий сонирхол биш ч байж болох зовнил надад байсан юм. Гэхдээ өнгөрсөн долоо хоногт бид хүлээж авсан захидлууд дахь асуултуудаа хараад миний буруу байжээ гэдгээ хэлэхэд таатай байна. Тэр ч байтугай эдгээр асуултуудын агуулга нь өнгөрсөн долоо хоногт бидний авч үзсэн асуудлуудын зарим нэгтэй холбоотой бөгөөд энэ долоо хоногт авч үзэх "философи нь шашин болон шинжлэх ухаантай хэрхэн холбогддог" тухай асуудлыг маань бага ч гэсэн наашлууллаа.

Өнгөрсөн долоо хоногт ярилцсан асуудлаа эргэцүүлж байхдаа 1940-өөд оны дундуур шиг санаж байна Чикагод Английн сурвалжит язгууртан, гүн, нэрт философич Бертран Расселтай би нэгэн мэтгэлцээнд оролцсоноо санасан юм. Тэр мэтгэлцээний таталган бичлэгийн мэдээ нь надад байдаг юм л даа. Рассел гүнтэн, бид хоёр "шинжлэх ухаан нь сайхан амьдрал болон сайн нийгмийг цогцлооход хүрэлцээтэй юү?" гэдэг сэдвээр мэтгэлцсэн юм. Мэтгэлцээнд гүнтэн "тийм" гэж, харин би няцаагч тал болсон бөгөөд "үгүй" гэж нотолсон. Яагаад би няцаагч тал болсон бэ гэвэл өнгөрсөн долоо хоногт би та бүхэнд шинжлэх ухаан бол яг үнэндээ сайхан амьдрал болон сайн нийгмийг цогцлооход хангалттай биш гэдгийг хэлэхдээ мэдэрсэн тэр зүйлээ тухайн үед мэдэрсэн юм. Хэрвээ өнгөрсөн долоо хоногт би та бүхэнд үнэн хэлсэн бол гүнтэн Расселд өгсөн миний хариулт ч бас үнэн. Шинжлэх ухаан нь их л сайндаа хэрэгслүүдийг болон ашиглах хүч чадлыг өгдөг болохоос эдгээр хэрэгслүүд болон хүч чадлыг хэрхэн хамгийн сайнаар ашиглахыг зааж чаддаггүй. Бас амьдралын төгсгөлд хүрэх чиг замыг ч зааж өгдөггүй.

Бид сүүлчийн удаа юуг авч үзсэнээ та бүхэнд хэлж чадаж байгаа шигээ энэхүү мэтгэлцээнийг тод санаж байна бас хэлсэн зүйлсийн маань зарим нь бүр тодорхой харагдаж байна. Инженерийн ухаан, анагаах ухаан, хууль гурав нь хүн төрөлхтөнд зориулан өөр өөр зүйлсийг хэрхэн бүтээдэг тухай ярилцсанаа та бүхэн санаж байгаа байхаа. Эдгээр гурван мэргэжил бол хүн төрөлхтний практикт зориулан гурван өөр зүйлийг бүтээдэг шиг соёлын агуу гурван салбар болох шинжлэх ухаан, шашин, философи нь хүн төрөлхтөнд зориулан мөн л гурван зүйлийг хийдэг.

Шинжлэх ухааны болон философийн аль алиных нь шийдэж чаддаггүй тийм практик асуултуудыг авч үзэх илүү хялбар ч байж болох юм. Ингэж няцааж авч үзэхийг минь зөвшөөрнө үү. Ямар асуултуудад шинжлэх ухааны эрдэмтэд хариулж чадахгүй вэ? Практик, бодит асуудлуудад. Шинжлэх ухааны эрдэмтэн аз жаргал гэж юу болох, аз жаргалд хэрхэн хүрч болох, жаргалтай байхын тулд хүн төрөлхтөн юу хийх ёстой вэ гэдэгт хариулж чадахгүй. Шинжлэх ухааны эрдэмтэн зөвхөн улс төрийн байгууллага болон зөвхөн эдийн засгийн ухаан нь нийгмийг хэрхэн бүтээх вэ гэдэгт бас л хариулж чадахгүй. Шинжлэх ухааны эрдэмтэн зөв гэж юу вэ?, буруу гэж юу вэ?, хүний үүрэг гэж юу вэ? гэдэгт ч хариулж чадахгүй. Шинжлэх ухааны эрдэмтэн яагаад хөдөлмөрийн аливаа хэлбэрүүд нь зэрэг дэвтэй байдгийг, яагаад тэнд нь боолын хүнд хүчир хөдөлмөр байх хэрэггүйг, яагаад бүх хүн эрх чөлөөтэй байх хэрэгтэй вэ гэдэгт хариулж чадахгүй. Товчоор хэлбэл, шинжлэх ухаан нь ёс суртахууны болон улс төрийн ганц ч суурь асуудлыг шийдэж чадахгүй. Харин эдгээр ёс суртахууны болон улс төрийн суурь асуудлууд нь философич, теологич хоёрын аль алиных нь хувьд тодорхой асуудлууд юм. Аль аль нь эдгээр асуудлыг шийдэх боломжтой.

Харин философийн хариулж чадахгүй асуулт юу байх вэ? Бурхан тэнгэр хүмүүст юу өгдөг вэ?, сайн нийгмийг удирдан чиглүүлэхэд болон сайн амьдралыг жолоодоход, түүнд хүрэхийн тулд хүмүүс бурхан тэнгэрээс хэрхэн тусламж авч чадах вэ? гэх мэт асуултанд философи нь бууж өгөх ёстой, өөрөөр хэлбэл энэ асуултыг шашинд үлдээхээс өөр аргагүй.

Мөн өнгөрсөн долоо хоногт бидний авч үзсэн нэгэн зүйлийг би давтмаар байна. Инженер, эмч хоёрын мэддэг юм нь өөр өөр учир гүүр барьж, өвчнийг эдгээх гэх мэт ялгаатай зүйлсийг хийдэг. Өөрөөр хэлбэл инженерийн ухаан болон анагаах ухаан нь хүмүүст зориулан өөр өөр юмыг хийдэг. Ингээд энэ нь л бидэнд асуудлыг бий болгож байна. Хэрвээ энэ нь үнэн юм бол философич, шинжлэх ухааны эрдэмтэн, шашин судлаач гурав нь ямар нэг өөр өөр юмыг мэддэг учраас хүний оршихуйн төлөөх гурван өөр практик зүйлсийг хийж чаддаг гэдэг нь бас үнэн. Соёлын энэхүү агуу том гурван салбар нь мэдлэгийн өөр өөр төрлүүд мөн үү?. Бид өнөөдөртөө энэ асуудал дээр л голлож анхаарлаа хандуулнаа гэж бодож байна. Ллойд оо бидэнд ирсэн асуултуудаас энэ хэлэлцүүлэгт хамаатайг нь авчрахгүй юу.

Шинжлэх ухаанууд бие даасан болох нь

Би өнөөдрийн хэлэлцүүлгийг таны надад өгсөн, хожим хэрэглээ гэж бодож байсан жишээгээрээ эхлээ гэж бодож байна. Ингээд мэдлэгийн гурван ялгаатай төрлүүдээс нэгэн жишээг авмаар байна. Гэхдээ зориуд түүх, хими, астрономи гурвыг сонголоо. Эдгээр нь мэдлэгийн илэрхий ялгаа бүхий төрлүүд гэдгийг бүгд л мэднэ. Түүхч болон түүхчийн хийдэг судалгаа, химичийн хийдэг судалгаа, мөн астрономичийн хийдэг судалгаа нь хоорондоо ялгаатай гэдгийг бүгдээрээ мэддэг.

Харин одоо энэ ялгааг илүү ойроос харцгаая. Түүх, хими, астрономи гурвын хоорондын ялгааг яаж бүр илүү тодорхой гаргах вэ? Өнөөдөр наад зах нь хоёр арга замаар тэдгээрийн ялгааг гаргахад таныг анхаараасай гэж би хүсэж байна. Өөрөөр хэлбэл объект болон судлах зүйлээрээ бас тэрхүү объектыг олж мэдэх аргаараа тэдгээр нь ялгаатай юм.

Түүхийн аргын онцлог нь өнгөрсөн үе дэх баримт нотолгоо, архелогийн туурь балгас, хөшөө дурсгал зэргийг ашиглаж судалгаагаа хийдэг. Эдгээр материалуудыг ашиглаж түүхийн объектыг судлах боломжтой бөгөөд түүх судлалын объект нь өнгөрсөн дэх үйл явдлууд юм.

Химичийн судалгааны арга нь багаж хэрэгслүүд, хуруу шил гээд л нарийн төвөгтэй тоног төхөөрөмжөөр хийгддэг туршилт билээ. Химич нь туршилтандаа ийм төрлийн багаж хэрэгслийг ашиглаж бодис, түүний элементүүдийн бүтэц, элементүүдийн нэгдэл, задрал зэргийг судалдаг.

Харин астрономич туршилт явуулдаггүй. Астрономичийн хувьд гол зүйл нь ажиглалт, энэ нь ч бас нарийн багаж хэрэгсэл тухайлбал аварга том телескопоор хийгддэг. Астрономич объектоо тухайлбал агуу том тэнгэрийн эрхсүүд, тэдгээрийн хөдөлгөөн гэх мэтийг телекопын ажиглалтаар хийдэг.

Ингээд бид мэдлэгийн энэхүү гурван төрөл нь объект болон аргаараа ялгаатайг авч үзлээ. Өөрөөр хэлбэл, мэдлэгийн эдгээр төрлүүд нэг нь нөгөөгөөсөө асар их хэмжээгээр хараат бус юм гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Ллойд оо шинжлэх ухаанууд нэг нөгөөгөөсөө хараат биш байдаг тухай асуудал дээр нэг асуулт байгаа шиг санагдаж байна, тийм асуулт бий билүү?

- Ллойд Лакман: За байз, ноён Ричард Хэчтээс ирсэн асуултыг хэлж байна уу?

- Мортимер Адлер: Тиймээ, тэр чинь мөн.

-Ллойд Лакман: Ноён Р.Хэчт Сан-Францискогийн 39-р гудамжинд амьдардаг. Тэрээр "Нэг шинжлэх ухаан нь нөгөөгийнхөө талбар руу халдаж болох эсэхийг мэдмээр байна" гэжээ.

- Мортимер Адлер: Аан, Ллойдоо энэ асуултанд лав хоёр хариулт байна. Бие биенээсээ харьцангуй хараат биш хоёр шинжлэх ухаан нь бие биенийхээ талбар руу халдаж болохгүй л дээ. Гэхдээ хоорондоо харилцан хамааралтай шинжлэх ухаанууд ч мэдээж байна л даа ноён Хэчт ээ. Жишээ нь биологи болон физик хоёрын харилцан хамаарал нь биофизикийг, астрономи болон физик хоёрын харилцан хамаарал нь астрофизикийг тус тус үүсгэдэг. Гэвч хоёр шинжлэх ухаан, мэдлэгийн хоёр төрөл нь үнэхээрийн тусгаар, бие даасан байвал тухайлбал түүх хими хоёр ч юмуу, хими астрономи хоёр нь нэг нь нөгөөгийнхөө судалгаа руу ороод байдаггүй шүү дээ.

Хэрвээ хоёр бие даасан шинжлэх ухаан нь үйл ажиллагаагаа зүй ёсоор нь явуулж, өөр өөрийнхөө судлагдахууны л асуултанд хариулж, өөрсдийн судлагдахууны хариултанд шүүмжлэлтэй хандаж чадвал ямар ч зөрчилдөөн үүсэхгүй шүү дээ. Миний бодлоор химич ба одон оронч, мөн түүхч ба химичийн хувьд энэ нь үнэн. Тэдгээр нь бие даасан мэдлэгийн төрлүүд бөгөөд үүний үр дүнд тэд зөрчилдөхөд хүрэхгүй юм.

Ялгаатай аргууд болон ялгаатай объектууд

Бид дөнгөж сая хими, астрономи, түүх гурвын ялгааг харцгаалаа, харин одоо манай соёлын агуу салбарууд болох шинжлэх ухаан, философи, шашин гурвын ялгааг авч үзэцгээе. Эхлээд би тэдгээрийг аргаараа ялгаатайг, дараа нь объектоороо ялгаатайг, эцэст нь бие даасан болохыг нь авч үзмээр байна.

Гэхдээ Ллойдоо би хатагтай Рянаас ирсэн философи, шашин, шинжлэх ухааны аргын талаар асуусан асуултыг эргэж хармаар байна. Тэр асуултыг уншаад өгөхгүй юу?

-Ллойд Лакман: Тэгье ээ, Тэр асуулт надад одоо энд байна л даа. Энэ бол Сан Франсискогийн хатагтай Рянаас ирсэн юм.

-Мортимер Адлер: Асуултыг нь сонирхцгооё.

-Ллойд Лакман: "Бид шашны итгэл бишрэлийнхээ зарим нэг зүйлсийг тэнгэрлэг, нууцлаг мэтээр хүлээж авдаг. Харин шинжлэх ухаанд бол туршилтгүйгээр, судалгаагүйгээр юуг ч хүлээн зөвшөөрдөггүй шүү дээ. Тэгвэл бид философид ямар арга зам болон үйл явцаар тогтоогдсон үнэнийг хүлээн зөвшөөрөх вэ?" гэж асуужээ.

-Мортимер Адлер: Ллойд Рян бидэнд асуусан асуулт шигээ зарим нэг дажгүй хариултыг өгчээ дээ. Тэрээр шашны объектыг тэнгэрлэг, нууцлаг гэсэн байна шүү дээ. Бас шинжлэх ухааны гол арга бол туршилт юм гэдгийг ч хэлж.

Лаборторидоо хуруу шилнүүдэд туршилтаа хийж байгаа химичийг бүгдээрээ төсөөлцгөөе л дөө. Энэ нь багаж хэрэгслүүдээр судалгаа хийж байгаа химичийн аргын дүрслэл юм. Одоо одон орон судлалынхаа төвд агуу том телескопоороо ажиглалт хийж байгаа астрономичийг төсөөлцгөөе. Тэгээд химич, астрономич хоёрын ялгааг сонирхоё. Астрономич бол одон орон судлалынхаа төвд ажиглалт хийж байгаа судлаач мөн. Химич ч бас лабораторидоо туршилтын багаж хэрэгслээрээ туршилт хийж байгаа судлаач мөн. Иймээс хатагтай Ряны хэлсэнчлэн шинжлэх ухааны арга бол зөвхөн туршилт гэж хэлмээргүй байна л даа. Харин бид шинжлэх ухааны судалгааны арга бол ажиглалт болон туршилт юм гэмээр байна.

Одоо шашны аргыг авч үзэцгээе. Шашны арга нь Бурхан тэнгэрийн илчлэл юм. Иудайн шашны агуу эпизодуудын нэг болох Шинай уулын орой дээрх бамбар бүхий 10 командмент буюу Бурхан тэнгэрийн хуулийг хүлээж авсан Моосуудыг төсөөлцгөөе л дөө. Мөн Есүс өөрийнхөө залгамжлагчид, шавь нартаагаа уулан дээр тахилга үйлдэж, хүн төрөлхтөнд хүргэсэн Бурхан тэнгэрийн үгийн илчлэлийг төсөөлцгөөе. Хүн төрөлхтний хүлээж авсан тэнгэрлэг илчлэл, илчлэлийн элементүүд нь шашинд нийтлэг болохыг энэ хоёр эпизодоос харлаа.

Тэгвэл философийн аргыг хэрхэн дүрслэх вэ? Философичийн багаж хэрэгслийн хамгийн чухал зүйл нь түшлэгтэй сандал юм. Ер нь хатуухан хэлэхэд философич бол сандал дээр суудаг сэтгэгч юм. Ямар философич сандлаасаа босоогүй байхдаа л ажлаа сайн хийнэ гэдгээ мэддэг. Аан тийм, философичид зарим нэг багаж хэрэгсэл хэрэгтэй л байх л даа. Тэр нь философичид нэг дэвтэр бас нэг үзэг хэрэгтэй. Тэдэнд энэ л байхад болно. Мэдээж философич нь математикчаас яг энэ талаараа ялгаатай биш л дээ. Математикч ч бас дэвтэр, үзэг хоёртой байхад ажиллаж чадна. Гэхдээ математикч бол цорын ганц түшлэгт сандалтай сэтгэгч. Харин философичид харилцан ярилцах нь чухал. Тэгэхээр философичийн аппарат хэрэгсэл нь ширээ тойрсон түшлэгтэй сандлууд байх нь.

-Ллойд Лакман: Надад Оакландад амьдардаг ноён Лейберманаас ирсэн яг үүнтэй холбоотой нэгэн асуулт байна. Тэрээр "Та өнгөрсөн долоо хоногт философи бол рациональ яриа бөгөөд хүн төрөлхтний оршихуйн хамтын ухаарлын хамгийн шилдэг жишээ гэж бүр онцлон хэлсэн" гэж бичсэн байна. Хамтдаа гэдгийг л бүр тодотгосон байх юм. Тэгээд ноён Лейберман нэг хүн, ердөө л тэр хүн дангаараа философич байж чадах уу? гэж асууж л дээ.

-Мортимер Адлер: Нэг л хүн философич байж чадах уу гэнээ, тиймээ ноён Лейберман, мэдээж чадна. Философийн агуу суутнууд өөрсдийн санаагаа ганцаараа л бясалгаж бүтээсэн байдаг. Гэхдээ философич бусадтайгаа харилцан ярилцах нь мөн нөхөдтэйгөө философийн агуу маргаан өрнүүлэх нь математикчаас илүү философичдод хавьгүй үр өгөөжтэй гэдэг нь үнэн юм. Яг үнэндээ философичид ганцаархнаа биш хэн нэгэнтэй хамтдаа эргэцүүлдэг нь философийн үнэнд хүрэхэд чухал юм гэж хэлмээр байна.

Одоо миний хоёр дахь гол асуудал буюу философи, шашин, шинжлэх ухаан гурвын объект нь ялгаатай болохыг авч үзье. Энэхүү гурван агуу салбар дахь аргын ялгаа нь юу байв? Шинжлэх ухаан бол судалгаа шинжилгээ мөн гэдгийг бид мэддэг. Шинжлэх ухаан нь шинжлэх, ажиглах ёстой, өөрөөр хэлбэл шинэ үзэгдэл, шинэ өгөгдлийг өгдөг. Энд ажиглалтын өгөгдлүүд дээр тулгуурладаг рациональ байгууламж болон томъёололыг бий болгоход оюун ухаан нь мэдрэхүйд үйлчилдэг. Философи бол рефлексив шинжтэй. Энэ бол хүн төрөлхтний нийтлэг туршлагын тухай суугаад бодоод бясалгаад анализ хийдэг гэсэн үг. Энд мэдрэхүй, ердийн туршлага оюун ухаанд үйлчилдэг. Шашин нь дээрх хоёртой харьцуулбал ухамтгай /receptive/ шинжтэй. Энэ нь бурхан тэнгэрийн илчлэлийг хүлээж авах хандлага бөгөөд энд оюун ухаан нь илчлэлийн үйлчилгээ болно.

Аргын энэхүү ялгаатай байдал нь тэдгээрийн объект нь гарцаагүй ялгаатай гэдгийг харуулж байна. Шинжлэх ухаан шинжилдэг учир түүний объект нь бүхий л үзэгдлүүд болон үзэгдлийн ертөнц юм. Философи нь рефлексив шинжтэй учир түүний объект нь үзэгдлийн, үзэгдэх байдлын цаана нь байх зүйлс, бодит байдал тэдгээрийн шалтгаан нь байна. Шашин нь тэнгэрлэг илчлэлийг хүлээж авагч шинжтэй учир түүний объект нь хатагтай Ряны хэлсэнчлэн тэнгэрлэг, нууцлаг зүйлс байна.

Философи нь шинжлэх ухаан болон шашнаас бие даасан болох нь

Шинжлэх ухаан нь судалгаа хийдэг. Энэ нь шинжлэх ухаан бол баримтуудыг дүрслэх боломжтой, баримтуудын тухай мэдлэгийг бидэнд өгдөг гэсэн үг.

Философи дүрслэхээс илүү рефлексив шинжтэй. Энэ нь бодит байдал болон шалтгааныг онцолдог. Философи нь дүрслэхээс илүү баримтуудыг тайлбарлахыг оролддог. Энд баримтуудыг тайлбарлах гэдэг нь бодит байдал, байгаль, амьдралын тухай суурь мэдлэг, тэдгээрийн талаарх зарим ойлголтыг бидэнд өгөхөөс дээгүүр зүйл юм.

Шашин нь итгэл бишрэлийг хүлээн зөвшөөрдөг. Хүлээн зөвшөөрч итгэнэ гэдэг нь хүмүүс энгийнээр мэдэж, ойлгож болохоос дээгүүр зүйл юм. Магадгүй философич, шинжлэх ухааны эрдэмтэн, шашин судлаач гурвын тус тусдаа хариулж чадах тийм асуултыг танд өгөх нь хамгийн сайн дүрслэл болох биз.

Шинжлэх ухаанчийн асуулт нь материйг хэрхэн атомын задралын энерги болгож хувиргах вэ? Энэ асуултанд Эйнштейн атомын задрал эсвэл нэгдэл дэх матери ба энергийн хоорондын тоон хамаарлын алдарт томъёог томъёолж хариулсан.

Бурхан тэнгэр цаг хугацааны эхлэлд ертөнцийг бүтээсэн эсэх асуудал нь шашинд хамаатай асуулт юм. Энэ нь анхны хуучин гэрээнд /Genesis/ бурхан тэнгэр газар дэлхийг бүтээсэн гэж байдаг эхний өгүүлбэр дэх тэнгэрлэг илчлэлийн асуулт юм.

Тэгвэл философичийн хариулах асуулт юу вэ? Яагаад бүхэлдээ өөрчлөгддөг ертөнцөд зарим мөнхийн зүйл байдаг юм бэ?, яагаад өөрчлөгдөшгүй зүйл хувирч өөрчлөгдөх ёстой юм бэ? гэх мэттэй төстэй асуултууд байна. Эсвэл бүр шашнаас болон шинжлэх ухаанаас философи нь юугаараа ялгаатай вэ? гэдэг асуулт бол зөвхөн философичийн л асуулт юм, өөрөөр хэлбэл энэ нь шинжлэх ухааны эрдэмтний ч, шашин судлаачийн ч асуулт биш.

Одоо бидэнд гурван асуулт маань тодорхой боллоо. Магадгүй би шинжлэх ухаан, шашин, философи гурвын бие даасан байдлын тухай их хурдан ярьсан байхаа. Ллойдоо, бидэнд шашин ба шинжлэх ухааны зөрчилдөөний тухай нэлээд хэдэн асуулт ирсэн, харин шинжлэх ухаан болон философийн эсвэл философи болон шашны зөрчилдөөний тухай бид ямар нэг асуулт хүлээж авсан билүү?

-Ллойд Лакман: Гурвуулангийнх нь зөрчилдөөний тухай нэг ч асуулт ирээгүй. Доктор Адлер, гэхдээ Калифорнийн Берклигийн хатагтай Жон Ворд Бабкок "Шашин, шинжлэх ухаан хоёрын хооронд хоёр талаасаа дайралт хийх талбар байхгүй, тэр талбар нь философи биш гэдэгтэй та санал нийлдэг үү?" гэж асуужээ.

-Мортимер Адлер: Хатагтай Бабкоктой санал нийлж байна л даа гэхдээ шинжлэх ухаан ба шашин хоёрын хооронд философи гарч ирсэн нь түүхэн шалтгаантай. Харин би таныг яг ямар утгаар хэлснийг тодруулахаар хоёр зүйлийг хэлмээр байна.

Эхнийх нь, манай соёлын агуу салбарууд болох шинжлэх ухаан, шашин, философи гурвын дунд хэзээ зөрчилдөөн гарч ирдэг вэ гэвэл тэдгээрийн нэг нь эзэгнэгч /империалистик/ болох үед, өөрийнхөө талбараас хальсан үед, нэг нь нөгөөгийнхөө територ луу халдаж түрэмгийлэгч болсон үед. Хатагтай Вавкок, философийн хувьд таны зөв өө, философийг дайнч хүчирхэг хоёр улсын хоорондох жижигхээн энх тайвныг эрхэмлэгч улстай зүйрлэж болох юм. Тэр улсад шинжлэх ухаан ба шашны зохист байрыг хадгалах хэрэг гарна, үнэндээ бол тэдгээрийг зөв дараалалд нь барьж байх хэрэг гарна.

Дээшлэх эрэмбэлэл

Бидний соёлын агуу салбарууд болох философи, шинжлэх ухаан, шашин гурвын хоорондох зохистой дарааллыг авч үзэх юм бол бид нэг алхам урагшлах болно. Эдгээрийн хооронд ямар зөв дараалал байх бол? Энд хоёр төрлийн хариулт байна л даа. Тэдгээр нь нэг бол нэг нь нөгөөтэйгээ зэрэгцсэн буюу тэнцүү байж болно, эсвэл тэдгээр нь доороосоо дээшилсэн эрэмбэлэсэн байж болно.

Шинжлэх ухаан, философи, шашин гурвын зөв дараалал нь юу байх вэ гэдэг асуулт дээр харилцан адилгүй хэд хэдэн үзэл байна. Жишээ нь шинжлэх ухаан, философи, шашин гурав нь ижил тэгш байр суурьтай гэсэн нэг үзэл байхад, мөн шинжлэх ухаан нь тэргүүн зэргийн ач холбогдолтой, харин

философи, шашин хоёр бол захриагдагч-дагалдагч шинжтэй гэсэн өөр нэг үзэл байна. Бас Францын позитивист философич Огюст Конт шинжлэх ухаан нь мэдлэгийн тогтолцоонд тэргүүлэх ач холбогдолтой, шашин нь сүсэглэгч шинжтэй, харин философи нь бясалгагч шинжтэй гэж үзжээ. Эдгээр бүх хариултууд л шинжлэх ухаан, философи, шашин гурвын хоорондох зөрчилдөөнийг бий болгож байгаа юм гэж би бодож байна.

Би энд эхлээд шинжлэх ухаанаас философи, шашин хоёр луу гэсэн шаталсан бүтэц бүхий нэгэн хувилбарыг дэвшүүлмээр байна. Энэхүү шатлалыг практик ойлголтуудаар тайлбарлая. Философи нь шинжлэх ухааныхаас илүү чухал ач тусыг хүмүүст хүргэдэг. Тэгвэл шашны хүмүүст хүргэдэг тус нь философийнхоос ч илүү юм. Харин онолын дараалал нь шинжлэх ухаанаас философи болон шашин руу чиглэсэн байх болно.

-Ллойд Лакман: Доктор Адлер Таны дөнгөж сая хариулсан хариулт бол Сан Францискогийн хатагтай Патрициа Деллээс ирсэн асуултын хариулт биш байна, тэрээр "Хэрвээ философи, шашин хоёроос сонгохыг танд тулгавал та философийг нь сонгох уу? Яагаад?" гэж асуужээ.

-Мортимер Адлер: Энэ их хүнд асуулт байна л даа, хатагтай Делл, Та ч намайг халуухан байдалд орууллаа даа. Би шударгаар хариулах ёстой ч энэ нь их хүнд, хүсмээр биш сонголт хэдий ч хэрвээ надад аль нэгийг нь сонго гэж тулгах юм бол хэдхэн мөчийн өмнө сонголтоо хэрхэн хийхээ хэлсэн шүү дээ. Хэрвээ хүмүүст хүргэдэг шашны тус илүү гэдэг нь үнэн бол шашин нь философиос илүү чухал учир философиос түрүүлж шашныг сонгох болно.

Гэвч би энэ сонголтыг хийхгүй гэж найдаж байна. Энд шашин, шинжлэх ухаан, философи гурвын хооронд зөрчилдөөн байх ёсгүйг л би хэлээд байгааг та ойлгосон байхаа гэж найдна. Энэ нь философи өөртөө зөрчилдөөн агуулдаггүй гэсэн санаа биш. Бас философийн тухай ямар нэг зөрчилдөөн байхгүй гэсэн санаа биш. Харин ч эсрэгээрээ философи бол маргаан, мэтгэлцээний хүлэмж л гэсэн үг. Философи нь маргаант асуудлуудаар дүүрэн байдаг. Яагаад философичдын санал нийлдэг дүгнэлт философид байдаггүй юм бэ? Яагаад философийн маш олон урсгал чиглэлүүд байдаг юм бэ?

Яагаад философид мөнхийн шийдэгддэггүй асуудлууд байдаг юм бэ?, эдгээр мөнхийн асуудлуудыг шийдвэрлэж болох уу?, философид дэвшилд хүрэх арга зам бий юу? гэх мэт эдгээр асуулт нь бидний дараагийн асуудал юм.

Жич: АНУ-ын нэрм судлаач Мортимер Жероме Адлер (Adler, Mortimer Jerome, 1902)-ийн *How to think about The Great Ideas from the Great Books of Western Civilization* (edited by Max Weismann) гэдэг бүтээлийн 2005 онд хэвлэгдсэн 7 дахь хэвлэлийн 466-475 талаас МУИС-ийн Философийн тэнхмийн эрхлэгч, доктор (PhD), профессор Т.Дорждагва, философийн ухааны магистр Л.Өнөржаргал нар орчуулав.